



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Ардын чуулган нам шинээр бүртгүүлэх
хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Х.Сонинбаяр, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардын чуулган нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардын чуулган намыг үүсгэн байгуулагч Ш.Сайхансамбуугаас: "... 2021 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Ардын чуулган намыг үүсгэн байгуулах хурлаар нийт гишүүдийн 100 хувийн саналаар намын даргаар сонгогдсон болно. Ардын чуулган намыг үүсгэн байгуулсан, удирдах зөвлөлийн гишүүд 10,000,000 төгрөг хандивласан бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу зарцуулагдах болно. Бидний ирээдүйн зорилгыг дэмжинэ хэмээн тус гишүүд гарын үсгээ зурж ирүүлсэн билээ. Ардын чуулган намын ирээдүйн зорилго бол Монгол Улс бүс нутгийн интеграц хамтын ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд өөрийн байр суурь оролцоогоо нэмэгдүүлэх, дэлхийн хөгжлөөс хоцрохгүй байх, улс төр, эдийн засаг, хөгжлийн тогтвортой байдлыг эрхэмлэн баримтлахад манлайлагч улс төрийн хүчин байх юм. Энэ нь юуны өмнө ард түмний хүсч хүлээж байгаа, хариуцлагатай засаглал, тогтвортой эрх зүйт төр, иргэд, олон түмэндээ хамгийн ойр, нийгмийн тогтвортой байдлыг, төрийг шинжлэх ухааны үндэслэлтэй байгуулах шаардлагыг үүсгэж байна. Иймд миний бие Монголын ард түмний хүсэл зорилгод нийцсэн Ардын чуулган намыг байгуулах хүсэлтээ уламжилж байна. Та бүхэн миний хүсэлтийг хүлээн авч нааштайгаар шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Ардын чуулган намыг улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх тухай хүсэлтийг дараах үндэслэлээр хангахгүй орхиж, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Улсын дээд шүүх намыг дараахь үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана: 10.1.3-т “гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн” гэж заасан байна.

Энэ тохиолдолд Ардын чуулган намаас “804 гишүүнтэй” гэж гишүүдийн бүртгэл шүүхэд ирүүлснийг нягтлан үзэхэд гишүүдийн тоо 801-д хүрээгүй буюу Ардын чуулган намын гишүүн биш-14, регистрийн дугаар алдаатай, улсын бүртгэлд бүртгэгдээгүй буюу бодит байдалд байхгүй мэдээлэлтэй хүн-36, нэр нь давхар бүртгэгдсэн 2 хүний зөрчил илэрчээ.

Мөн Ардын чуулган нам болон Ардын намын давхар гишүүнчлэлтэй 1, гишүүдийн бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зураагүй 4 тохиолдол тогтоогджээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа этгээд нь бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө” гэж заасан, тус намыг үүсгэн байгуулагч нараас гишүүдийн бүртгэлд бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг үнэн зөв гаргаж өгөөгүй, гишүүдийг давхардуулан бүртгэсэн, улсын бүртгэлгүй, бодит байдалд байхгүй хүний мэдээлэл ирүүлсэн, түүнчлэн гишүүд нь өөр намын гишүүн биш гэдгийг болон өөр хүнээр төлөөлүүлж намд элсээгүй гэдгийг нотолсон баримтыг шүүхэд ирүүлээгүй байна.

Мөн Намын их хуралд орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг хэрхэн сонгож оролцуулсан нь тодорхой бус, Төлөөлөгчдийн бүртгэлийн дэвтэрт орон нутгаас 13, Улаанбаатар хотоос 25 төлөөлөгч гэсэн, орон нутгийн 13 хүнээс 4 нь хаягийн бүртгэл зөрүүтэй, аль аймгийн төлөөллийг хэрхэн сонгосон болох нь тодорхойгүй, гишүүдийн бүртгэлийг цахимаар ирүүлээгүй нөхцөл байдал тогтоогдов.

Иймд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ардын чуулган намын “гишүүдийн тоо 801-д хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, өөрөө биечлэн бүртгэлд гарын үсэг зураагүй буюу өөр хүн төлөөлсөн” гэсэн үндэслэлүүдээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж, хууль болон намын дүрэмд нийцүүлэн хурлаа зохион байгуулсны дараа холбогдох хүсэлтээ гаргах эрхтэй болохыг тэмдэглэн шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардын чуулган намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.
2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ